



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 17/491

Арвайхээр

Г Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах тухай Г

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь дууссан иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг харгалзан Думаажавын Батбаяр (ХВ53122078)-ын эзэмшил Арвайхээр сумын 5 дугаар баг, Б.Ренчинпэлжээгийн гудамж, 149 тоотод байрлах үйлчилгээний зориулалттай 1095м<sup>2</sup> газар, ЕЕСС ХХК (2043688)-ийн эзэмшил 5 дугаар баг, Шинэ Арвайхээр гудамж, 409 тоотод байрлах үйлдвэрлэлийн зориулалттай 1712м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг тус тус 15 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь сунгагдсан иргэн, аж ахуйн нэгжтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

ОРЛОГЧ



Ө.БАТЖАРГАЛ

011101077